

# МОНГОЛ УЛСЫН ЗАСГИЙН ГАЗРЫН ХУРАЛДААНЫ ТЭМДЭГЛЭЛЭС

ЗАМ, ТЭЭВРИЙН ХӨГЖЛИЙН ЯАМАНД

Монгол Улсын Засгийн газрын 2018 оны 5 дугаар сарын 16-ны өдрийн хуралдааны 21 дүгээр тэмдэглэлд:

“XXIX.1. Гамшгийн эрсдэлийг бууруулах Азийн сайд нарын II бага хурлын бэлтгэл ажлын явц, цаашид авах арга хэмжээний талаар Монгол Улсын Шадар сайд Θ.Энхтүвшин Засгийн газрын гишүүдэд танилцуулав. Үүнтэй холбогдуулан дор дурдсан арга хэмжээ авч хэрэгжүүлэхийг холбогдох сайд, Засгийн газрын агентлагийн дарга, нийслэлийн Засаг дарга нарт тус тус даалгав:


1. Гамшгийн эрсдэлийг бууруулах Азийн сайд нарын бага хурлаас гарах үндсэн баримт бичгүүдийн төсөлд санал өгөхийг Засгийн газрын гишүүдэд;
2. Хурлын үеэр гадаадын зочид, төлөөлөгчдөд үзүүлэх урлагийн тоглолтыг Үндэсний их баяр наадмын урлагийн тоглолтын хөтөлбөрт зохицуулалт хийх замаар зохион байгуулахыг Монгол Улсын Шадар сайд, Үндэсний их баяр наадмыг зохион байгуулах хорооны дарга Θ.Энхтүвшинд;
3. Хурлын үеэр өндөр түвшний зочид, төлөөлөгчдөд үйлчлэх тээврийн хэрэгслийг Засгийн газрын авто баазаас гаргахыг Монгол Улсын сайд, Засгийн газрын Хэрэг эрхлэх газрын дарга Г.Занданшатарт;
4. Хурлын үеэр гадаадын зочид, төлөөлөгчдөд үйлчлэх том болон дунд оврын автобусаар хангах ажлыг зохион байгуулахыг Зам, тээврийн хөгжлийн сайд Ж.Бат-Эрдэнэд;
5. Гадаадын зочид, төлөөлөгчдийг аялал жуулчлалтай холбоотой мэдээллээр хангах, аялал жуулчлалын цахим хуудсыг Азийн сайд нарын бага хурлын цахим хуудастай холбох, олон улсын үзэсгэлэнд монголын аялал жуулчлалын салбарын төлөөллийг оролцуулах ажлыг хариуцан зохион байгуулахыг Байгаль орчин, аялал жуулчлалын сайд Н.Цэрэнбатад;
6. Хурлын үеэр гадаадын зочид, төлөөлөгчдийн эрүүл мэнд, аюулгүй байдлыг хангаж ажиллахыг Эрүүл мэндийн сайд Д.Сарангэрэл, Тагнуулын ерөнхий газрын дарга Д.Гэрэл, Онцгой байдлын ерөнхий газрын дарга Т.Бадрал, Цагдаагийн ерөнхий газрын дарга С.Баатаржав нарт;
7. Монголын сэтгүүлчдийн нэгдсэн эвлэл болон “МОНЦАМЭ” агентлаг, телевизүүдийн холбоо зэрэг хэвлэл мэдээллийн байгууллагуудтай хамтран ажиллаж, хурлын үйл ажиллагааг сурталчлах ажлыг зохион байгуулахыг Засгийн газрын Хэвлэл мэдээлэл, олон нийттэй харилцах хэлтсийн дарга Ц.Ганзоригт;

8. Хурлын үеэр зочид, төлөөлөгчдийн хоол, хүнсний аюулгүй байдлыг хангуулах, түүнд хяналт тавьж ажиллахыг Мэргэжлийн хяналтын ерөнхий газрын дарга Н.Цагаанхүүд;

9. Бага хуралд оролцох гадаадын зочид, төлөөлөгчдөд виз олгох болон гаалийн шалган нэвтрүүлэх цэгийн үйл ажиллагааг шуурхай болгох арга хэмжээ авч ажиллахыг Гадаадын иргэн, харьяатын газрын дарга Д.Мөрөн, Гаалийн ерөнхий газрын дарга Б.Асралт, Иргэний нисэхийн ерөнхий газрын дарга Л.Бямбасүрэн нарт;

10. Гамшгийн эрсдэлийг бууруулах Олон улсын үзэсгэлэнгийн бэлтгэл ажлыг ханган Сүхбаатарын талбайд зохион байгуулах арга хэмжээ авахыг Нийслэлийн Засаг дарга бөгөөд Улаанбаатар хотын захирагч С.Батболд, Онцгой байдлын ерөнхий газрын дарга Т.Бадрал нарт;

11. Монгол Улсыг төлөөлөн Азийн сайд нарын бага хуралд оролцох албан хаагчдын нэrsийн жагсаалтыг гаргаж 2018 оны 6 дугаар сарын 10-ны дотор хурлын цахим хаяг ([www.unisdr.org/conference/2018/amcdrr](http://www.unisdr.org/conference/2018/amcdrr))-аар бүртгүүлэх, нэrsийг баталгаажуулах ажлыг зохион байгуулахыг нийт төрийн байгууллагуудын дарга нарт.



ЗАСГИЙН ГАЗРЫН ХЭРЭГ ЭРХЛЭХ ГАЗАР